

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРЭГ, ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛД ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ

Ч.Батболд.

ДХИС-ийн Удирдлагын академийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн
удирдлага, стратегийн тэнхимийн
ахлах багш, хууль зүйн доктор
(Ph.D), дэд хурандаа

Хураангуй: Хорих байгууллага нь хорих ял эдэлж буй хоригдол, цагдан хоригдож буй хоригдогсдын зүгээс гэмт хэрэг үйлдэх, нийгэм, иргэдийг гэмт халдлагад өртөхөөс хамгаалах, урьдчилан сэргийлэх чиг үүргийг хэрэгжүүлэн ажилладаг төрийн тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллага юм.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, хорих байгууллагын орчин, нөхцөл зэрэг цөөнгүй шалтгааны улмаас хорих байгууллагын аюулгүй байдалд халдах, оргон зайлах гэмт явдал гарсаар байна.

Иймд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын өнөөгийн нөхцөл байдалд шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга замыг тодруулахыг зорьсон болно.

Түлхүүр үг: Биечилсэн хамгаалалт, техникийн хяналт, нийгэмшүүлэх ажил, сэтгэл зүйн үйлчилгээ, гүйцэтгэх ажил, гэмт хэрэг, зөрчил, урьдчилан сэргийлэх.

Үндсэн хэсэг.

Энэхүү илтгэлээр иргэн, захиргаа, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа биш зөвхөн эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа тэр дундаа хорих ял эдлүүлэх ажиллагааны үед хоригдлын зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд судалсан болно.

Дэлхийн эрүүгийн ялын бодлогын чиг хандлага гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тохирох ял, шийтгэлийг хүлээлгэн, тухайн этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэгдсэн ялын гүйцэтгэлийн олон талт арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдэж байна.

Монгол Улс ч энэхүү чиг хандлагыг баримтлан эрүүгийн хариуцлагын зорилгыг гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх болон гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх явдал хэмээн эрх зүйн зохицуулалтын хүрээнд ялын гүйцэтгэлийн бодлогыг тодорхойлсон билээ.

Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь ялын бодлого, зорилгыг хангахад чиглэх ба ялын бодлого нь тухайн улс орны хөгжлийн үе шат дахь нийгэм, эдийн засаг, улс төр, эрх зүйн хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг хангах, хүний эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах чиг үүрэг хэрэгжүүлэхэд төрөөс баримталж буй чиглэл бөгөөд төр эрүүгийн ялын бодлогоо хариуцлагын оновчтой төрөл, тогтолцоог бий болгох, оногдуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, түүгээр дамжуулан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх зэрэг арга хэрэгслээр дамжуулан хэрэгжүүлдэг¹ хэмээн тодорхойлсон.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үед хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр явуулж буй ажлын өнөөгийн байдлыг дараах чиглэлээр судалж үзлээ. Үүнд:

1. Техникийн хяналт хамгаалалт:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4.27-т “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын технологийн дэвшлийг инновацад суурилан хөгжүүлнэ.”, 7.4.29-т “Хоригдогсдын хорих анги, байгууллагын дотоод үйлчилгээнд цахим картын системийг нэвтрүүлнэ.”, 7.4.30-д “Хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ.”, 7.4.31-д “Дараа үеийн суурин болон хөдөлгөөнт холбооны технологийн дэвшилд тулгуурласан цагдаа, дотоодын цэрэг, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон харилцаа холбооны шийдлийг нэвтрүүлнэ”² гэж тус тус заасан.

Хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагааг явуулахад дан ганц хүний хүчээр хийх нь учир дутагдалтай бөгөөд техник хэрэгслийг ч мөн өргөн ашиглах нь хөдөлмөрийг хөнгөвчлөх, цаг хэмнэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зэрэг олон давуу талтай. Мэдээллийн технологи эрчимтэй хөгжиж байгаа өнөө үед тоон технологийн телекамерын хяналтын ач холбогдол, хэрэгцээ, шаардлага улам бүр өсөн нэмэгдэж, үүний хэрээр технологийн шинэ дэвшлүүд сүүлийн жилүүдэд манай улсад маш хурдацтай нэвтэрч байгаатай шууд холбоотой бөгөөд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагаанд орчин үеийн технологийн шийдлийг нэвтрүүлэх талаар томоохон бодлогын арга хэмжээнүүд тусгагдсан нь цаг үеэ олсон ажил гэж судлаачийн зүгээс үзэж байна.

¹ Батболд, Ч. Хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажил. Докторын зэрэг горилсон бүтээл. Уб., 2023. 5 дахь тал.

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг.

Хорих байгууллагын албан хаагчдын үйл ажиллагааны стандартад гадна хамгаалалтад үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдын үүрэг гүйцэтгэлд ашиглах баримт бичиг, бүртгэл, судалгаа, хамгаалалтын бүс, түүний техник хэрэгсэл, хоригдол, иргэд болон эд зүйлд хийх үзлэг, нэгжлэг хийх тухай ойлголт зэргийг нарийвчлан тусгасан. Тухайлбал, хорих ял эдэлж байгаа хоригдлын дундаас гарч болзошгүй орголт, гэмт хэрэг зөрчил болон нийтийг хамарсан эмх замбараагүй байдал бий болох, бусдыг барьцаанд авах, суулт зарлах, гаднын гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд хоригдлын амьдралын бүсэд нэвтэрч буй алба хаагч, хоригдол, иргэд, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих, хамгаалалтын бүсийн техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг хангах, хамгаалалтын бүсэд үзлэг, шалгалт хийж хориотой эд зүйлийг хураан авах талаар нарийвчлан зохицуулсан.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 2 жилийн хугацаанд харьяа салбар нэгжид ашиглагдаж буй телекамерын системийг аналогич технологиос орчин үеийн тоон технологид (IP) шилжүүлэх ажлыг үе шаттайгаар шинэчлэн нийт ашиглагдаж байгаа телекамерын 93%-ийг шинэчилж 401 дүгээр хаалттай хорих анги, нэгдсэн эмнэлэг, 421 дүгээр нээлттэй хорих анги, 423 дугаар нээлттэй, хаалттай хорих анги, 429 дүгээр хаалттай хорих анги, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, 461 дүгээр хаалттай хорих анги, Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага зэрэг нийт 6 нэгжид гадна хамгаалалтын цахилгаан дохиоллын LANSTAR системийг нэвтрүүлэн ашиглалтад оруулаад байна.

2. Биечилсэн хяналт, хамгаалалт:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь 54 нэгжид 3100 алба хаагчийн орон тоонд 3000 орчим албан хаагч ажиллаж байна. Үүнээс эрэгтэй 67.5 хувь, эмэгтэй 32.5 хувийг, офицерын бүрэлдэхүүнд 39.3 хувь, ахлагчийн бүрэлдэхүүнд 50.4 хувь, энгийн 10.2 хувийг тус тус эзэлдэг бол нийт алба хаагчдын 31,4 хувь нь хоригдол, хоригдогчтой өдөр тутам харьцдаг хамгаалалтын ажилтан албан тушаалд ажиллаж байна.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”¹-аар нээлттэй, хаалттай хорих ангиудад 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон.

¹ Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал

Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар ажилтан 8 цаг буюу 7 хоногт 40 цаг ажиллах заалтын дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагч сард 160 цаг, жилд 1920 цаг ажиллах ёстой боловч 24 цагаар жижүүрлэлтийн үүрэг гүйцэтгэхээс гадна шуурхай цугларалт, албаны бэлэн байдал, хүчлэн хамгаалалт зэрэг онцлог цаг үеэр илүү цагаар ажилласныг оролцуулахгүйгээр ажлын шаардлагаар сард 240 цаг, жилд 2880 цаг ажиллаж байна.¹

2024 оны 11 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар хорих ял эдэлж байсан 4580, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан 1075 хоригдогсдод 556 хамгаалалтын ажилтан 4 ээлжид хуваагдан хяналт тавьж байсан ба 1 хамгаалалтын ажилтанд дунджаар 37-40 хоригдол ноогдож байжээ. Дээрх үзүүлэлт нь хамгаалалтын ажилтан ээлжийн амралттай, томилолттой, сургалтын болон гачигдлын чөлөөтэй байсан зэргийг үл харгалзан бүрэн бүрэлдэхүүнээр ажилласан тохиолдолд л биелэгдэх боломжтой үзүүлэлт гэдгийг анхаарах нь зүйтэй.

3. Хорих анги дахь гүйцэтгэх ажил:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх хэсэгт “... хоригдол оргох, үймээн гаргах, бусдыг барьцаанд авах, хорлон сүйтгэх зэрэг ноцтой гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, тэдгээрийн урьд үйлдсэн болон хорих анги дотор гарсан хэргийг илрүүлэх, түүнчлэн оргосон хоригдлыг баривчлах түүнчлэн тагнуул, цагдаа, авлигатай тэмцэх байгууллагын гүйцэтгэх ажилд дэмжлэг үзүүлэх зорилгоор гүйцэтгэх ажил явуулна” гэж заасны дагуу хорих ангид гүйцэтгэх ажил явуулж гэмт хэрэг үйлдэж болзошгүй хоригдлыг илрүүлэн харуул хамгаалалтыг зөв зохион байгуулж, урьдчилан сэргийлж ажилладаг.

Хорих ангид гүйцэтгэх ажил явуулах журам, зааврыг гүйцэтгэх ажлын тухай хууль тогтоомжид нийцүүлэн тагнуулын төв байгууллагын дарга шүүхийн шийдвэр гүйцэтгэх төв байгууллагын даргатай зөвшилцөн батална.

4. Нийгэмшүүлэх ажлын чиглэлээр:

Нийгмийн ажил нь хүний амьдралын ертөнцөд алдагдаж гээгдсэн тэрхүү “социаль”-ийг эргүүлэн авч ирэхийн төлөө байдаг бөгөөд нийгмийн ажилтан ядуу, ажилгүй, хөгжлийн бэрхшээлтэй, хүчирхийллийн хохирогч, архичин, мансуурагч өнчин болон хараа хяналтгүй хүүхэд, хоригдол, гэмт хэргийн хохирогч, өрх толгойлсон эцэг эх, харилцааны асуудалтай гэр бүл, нийгмээс ялгаварлагдсан, гадуурхагдсан болон тусламж хэрэгтэй бүхий л хүмүүст амьдрах итгэлийг өгөхөд бүхий л хүч хөдөлмөрөө зарцуулж байдаг өвөрмөц мэргэжилтэн билээ.

¹ Монгол Улс дахь Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 15 дахь илтгэл 181 дэх тал

Хоригдлыг нийгэмшүүлэх асуудал нь хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад болон ял эдлээд суллагдсаны дараа гэмт хэрэг зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, гэмт зуршлаас нь татгалзуулах, хуулиа сахидаг (law binding) иргэншсэн бие хүн болон төлөвшүүлэх, нийгмийн амьдралд буцаан нэгтгэхэд чиглэсэн сэтгэл зүй, нийгмийн ажил, эрх зүй, менежментийн цогц арга хэмжээ¹ гэж ойлгож болно.

Хорих байгууллагад явуулах нийгмийн ажлын үйлчилгээ нь хорих байгууллагын зүгээс хоригдолд чиглэсэн нийгмийн ажлын үйлчилгээг үе шаттай, үр дүнтэй явуулснаар тэднийг нийгэмшүүлэх буюу нийгэмд нь эргэн нэгтгэх (resocialization, reintegration into society), суллагахаас өмнө эрх чөлөөт амьдралд нь бэлтгэх, суллагдаж гараад дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдэн явагддаг.

Үүнийг онолын үүднээс тайлбарлавал тусгайлан боловсруулсан хөтөлбөр, сургалтын дагуу тухайн хоригдлын зан байдал, хувийн онцлог, нас хүйс зэрэг онцлогийг харгалзан ялгамжтай явуулдаг нийгмийн ажлын мэргэжлийн үйлчилгээгээр дамжин хэрэгжиж үр дүн нь гардаг байна.

Бусад улсын туршлагад хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр тодорхой төлөвлөгөө боловсруулж, тэднийг нийгэмшүүлэхэд чиглэсэн олон хууль, эрхийн акт, хөтөлбөр хэрэгжүүлж ихээхэн туршлага хуримтлуулж байна.

Манай улсын хорих байгууллага дахь нийгмийн ажлын агуулга, зохион байгуулалт, эрх зүйн орчин, үйл ажиллагааг олон улсын хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн бүрэлдүүлэхэд бусад орны энэ талаар хуримтлуулсан арвин туршлага, алдаа онооноос суралцах нь зохистой юм.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны үр дүнг дээшлүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөвхөн хуульд зааснаар хязгаарлах явцад гэмт хэрэг үйлдэж буй хүнийг дахин нийгэмшүүлэхийн тулд боловсрол олгох, мэргэжил, мэдлэгийг дээшлүүлж хөдөлмөрийн дадлага, туршлага олгоход чиглэгдсэн үйл ажиллагааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218-222 зүйлүүд болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын тушаалаар батлагдсан “Нийгмийн ажилтны ажлын заавар”, “Сэтгэл зүйчийн ажлын заавар”-аар зохицуулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь хоригдлын эрхийг хангах, хамгаалах чиглэлээр олон улсын стандарт шаардлагад нийцүүлэн хоригдлын амьдралын бүс, хоол хүнс, ахуй нөхцөл зэрэг материаллаг хэрэгцээгээр нь дамжуулж нийгэмшүүлэх ажлыг түлхүү зохион байгуулж ирсэн уламжлалтай.

¹ Баттулга Г. “Хорих ял эдлэгсдийг нийгэмшүүлж буй олон улсын туршлага” “Хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл, 2016 он, 8 дахь тал

2018 онд нийгэмшүүлэх ажлыг эрчимжүүлэх, үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор “Нийгмийн ажилтны аргачилсан заавар”-ыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нийцүүлэн шинэчлэн найруулж, үйл ажиллагаандаа мөрдөж эхэлсэн нь нийгэмшүүлэх үйл ажиллагааг үе шаттайгаар, үр дүнг тооцон, хэрэгжилтэд хяналт тавих боломжийг бүрдүүлж өгсөн.

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүмүүнлэг иргэний ардчилсан нийгэм байгуулах зорилтыг өөрийн өвөрмөц чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж, ял эдлүүлэх үйл ажиллагааны агуулгыг сайжруулахад чиглүүлж, ял эдлэгсдийн оюун ухаанд эерэг зөв мэдлэг олгох, нийгэмшүүлэх нь юу юунаас ч илүү чухал юм.

2023 онд сэтгэл зүйн үйлчилгээ авсан хоригдлын тоон үзүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад шинээр болон шилжин ирсэн хоригдолтой уулзсан хоригдлын тоо 656 буюу 22,5 хувь, төлөвлөгөөт уулзалт зохион байгуулсан хоригдлын тоо 255 буюу 6 хувиар тус тус өссөн, ганцаарчилсан уулзалт зохион байгуулсан хоригдлын тоо 573 буюу 6 хувь, бүлгийн уулзалт зохион байгуулсан хоригдлын тоо 116 буюу 1,5 хувиар тус тус буурчээ.

Сэтгэл зүйн тодорхойлолт гаргасан хоригдлын тоо 824 буюу 20 хувиар буурсан үзүүлэлтэй, холбон зуучлах хуудсаар танилцуулсан хоригдлын тоо 31 буюу 4 хувь, сахилгын зөрчил гаргасан хоригдолтой уулзалт хийсэн тоо 80 буюу 29 хувиар тус тус өссөн байна.

Хоригдлын эрэлт, хэрэгцээ болон дахин гэмт хэрэг үйлдсэн хоригдлын харилцааны ур чадварыг одоо хэрэгжүүлж буй нийгэмшүүлэх үйл ажиллагаатай холбон судалсан судалгаанаас үзэхэд нийт хоригдлын 47.3 хувь нь харилцааны ур чадвар дунд анхаарах, 34.8 хувь нь харилцааны ур чадвар муутай буюу анхаарах нэн шаардлагатай гэсэн үр дүн гарчээ.

Иймд харилцааны ур чадварыг сайжруулах, мэргэжил эзэмшүүлэх, бие хүний төлөвшилд эерэг нөлөөлөл үзүүлэхэд чиглэсэн сургалтын хөтөлбөр шаардлагатай гэж үзсэн тул Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/207 дугаар тушаалаар “хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”-ийг баталж хэрэгжүүлж байна.

Энэ хөтөлбөр нь хоригдлыг нийгэмшүүлэх ажлыг хөдөлмөр, сургалттай хослуулан, мэдлэг боловсролыг дээшлүүлэх, амьдралын зөв дадал, харилцааны эерэг зан үйлийг төлөвшүүлэх зорилготой юм.

Сургалтыг гэмт хэргийн хор уршгийг ойлгуулах, хууль, эрх зүйн мэдлэг олгох, харилцаа, хандлага, зан чанарт эерэг нөлөөлөл үзүүлэх, амьдралын зөв дадал, хэвшил олгож, нийгмийн амьдралд ухамсартайгаар бие даан амьдрах чадвар эзэмшүүлэх агуулгын хүрээнд төрийн болон төрийн бус байгууллага

иргэнийг хамруулан зохион байгуулахаар зохицуулжээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас санаачлан хоригдлыг нийгэмшүүлэх чиглэлээр хэрэгжүүлж эхлээд буй томоох ажил бол Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/167, А/233 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хоригдлыг суллахад бэлтгэх хөтөлбөр” юм.

Тус хөтөлбөрийн зорилго нь хорих ялын хугацаа дуусахаас өмнө хоригдлыг нийгэмд гарахад бэлтгэх, суллагдсаны дараа дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, суралцах, ажил хөдөлмөр эрхлэх дадал хэвшүүлэх, гэр бүлийн харилцаа, хөдөлмөрийн харилцаанд бэлтгэх, нийгэмшүүлэхэд чиглэсэн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын зүгээс үзүүлэх нийгмийн ажил, үйлчилгээний салбар дундын зохицуулалтыг хангахад оршиж байгаа билээ.

Тус хөтөлбөрийн хүрээнд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагууд хоригдлыг суллахад бэлтгэхэд чиглэлээр дараах арга хэмжээг хэрэгжүүлэхээр болсон юм. Үүнд:

Өнөөгийн байдлаар “хорих ял эдлүүлэх үеийн сургалтын жишиг хөтөлбөр”, “суллахад бэлтгэх хөтөлбөр” хэрэгжиж байгаа нь сайшаалтай боловч хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэлтэй, боловсролын зэрэг, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөрийг боловсруулах шаардлагатай гэж үзлээ.

Дүгнэлт.

Өнөөгийн хорих байгууллага дахь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хэрэгжилт, үр дүнд шинжилгээ хийснээс гадна хорих байгууллагад хэрэгжүүлэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга зүйг боловсронгуй болгох асуудлыг хөндөж, дараах дүгнэлтийг хийлээ. Үүнд:

1. Өнөөгийн нөхцөл байдлаас үзвэл хоригдлын үйлдэж болзошгүй гэмт хэргийн нийгмийн хор уршиг, аюул эрсдэл багагүй өндөр түвшинд байгаа нь харагдаж байна. Тухайлбал, сүүлийн жилүүдэд шинэ төрлийн гэж хэлж болохуйц нийгмийн хор аюул өндөртэй гэмт хэрэгт хорих ял шийтгүүлсэн хүний тоо өссөн, тэдгээрийн зүгээс хорих байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулах,

өөрийн хувийн хүсэл зоригоо гүйцэлдүүлэх болон бусад хэлбэрээр гэмт хэрэг, зөрчилд бэлтгэх явдал багагүй тогтоогдож байна.

2. Хорих байгууллагын техник хэрэгслийг олон улсын жишигт нийцүүлэх, аюулгүй байдлын шаардлагатай уялдуулан шинэчлэх хэрэгцээ үүсээд байна. Өөрөөр хэлбэл, хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд хоригдлын гэмт санаа бодол, үйлдлийг нарийвчлан тооцох хүчин чадал бүхий технологийн дэвшилтэд шинэ тоног төхөөрөмжийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд өргөнөөр ашиглах шаардлагатай гэж үзлээ.

3. Өнөөгийн байдлаар хоригдлын зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, болзошгүй гэмт явдалтай тэмцэх чиглэлээр бие даасан, мэргэшсэн бүтэц дутмаг, хорих байгууллагад хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх чиглэлээр албадын хамтын ажиллагааг сайжруулах гэж үзлээ.

4. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэл, боловсрол, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх хэрэгцээ үүссэн гэж дүгнэж байна.

Санал.

хорих ял эдлүүлэх ажиллагааны үед хоригдлыг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулах чиглэлээр дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хоригдлын үйлдэл, эрүүл мэнд, сэтгэл зүй, хувийн байдлыг нарийвчилсан түвшинд судлан тогтоох ажилд шинжлэх ухаан технологийн дэвшлийг ашиглах. Үүнд:

а) Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 243 дугаар зүйлийн 243.3 дахь хэсэгт “хоригдол, хорих ангийн алба хаагчийн аюулгүй байдлыг хангах зорилгоор хорих өрөө, хорих анги дотор хоригдол зорчих бусад хэсгийг хамарсан дуу-дүрсний бичлэгийн хяналтыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага зохион байгуулна” гэж заасны дагуу нүүр царай таних телекамерын системийг нэвтрүүлэх;

б) “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 7.4.29-т “хоригдогсдын хорих анги, байгууллагын дотоод үйлчилгээнд цахим картын системийг нэвтрүүлнэ”, 7.4.30-д “хүний биеийн давхцахгүй өгөгдөл бүхий бүртгэл, танилтын системийг нэвтрүүлнэ” гэж заасны дагуу хоригдлын хөдөлгөөн, байршил болон зүрхний цохилт, эрүүл мэндийн

байдлыг байнга хянаж байх цахим хяналтын тогтолцоог бий болгох.

2. Хорих байгууллагын хүний нөөцийг бүрдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зоригоор “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д зааснаар нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, аюулгүй байдлын алба хаагчдын орон тоог нэмэгдүүлэх.

3. Хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, сэтгэцийн онцлог, анх болон удаа дараагийн ял шийтгэл, боловсролын зэрэг, нийгмийн гарал байдал зэрэг зүйлсийг харгалзан тухайн бүлэг хоригдолд чиглэсэн нийгэмшүүлэх тусгайлсан хөтөлбөрүүдийг шинээр боловсруулж, үйл ажиллагаанд нэвтрүүлэх зэрэг болно.